



МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 334

Улаанбаатар хот

Г Зөвшөөрөл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн "Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тооны хязгаар тогтоох тухай" 377 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай" 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг хавсралт ёсоор батлахыг аймгийн Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

2. Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилтийг Төрийн хэмнэлтийн тухай хууль, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын төрийн бүтээмжийг сайжруулах зорилт, төрийн албаны шинэтгэлийн үйл явцтай уялдуулан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газарт үүрэг болгосугай.

3. Хянаж зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтыг албажуулах, баталж мөрдүүлэх, нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллахыг Ажлын алба /Ж.Эрдэнэбат/-нд даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 44 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



Төрийн албаны зөвлөлийн  
2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн  
334 дүгээр тогтоолын хавсралт

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан  
шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон  
Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг  
баталсан огноо:

Байгууллагын нэр:

.....аймгийн  
Засаг даргын Тамгын газар

Нэгжийн нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Засаг даргын Тамгын газрын дарга

Эрхэлсэн түшмэл, ТЗ-13

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Нутгийн удирдлагын ордон

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Төрийн бодлого, хууль тогтоомж, стратегийн зорилтыг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, хяналт тавих, аймгийн Засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, Засаг даргад бодлогын зөвлөгөө мэргэшил аргазүйн дэмжлэг үзүүлж, мэдээллээр хангах, Тамгын газрын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг аймгийн Засаг даргын өмнө хариуцан тайлagnана.

**Албан тушаалын зорилт:**

1. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тооцох;
2. Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг төлөвлөх, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих;
3. Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, мэргэшил арга зүйн удирдлагаар хангах;
4. Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;
5. Тамгын газрын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, тайлagnaх, хяналт тавих.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1. Монгол Улсын Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Шинэ эргэлтийн бодлого, улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн орон нутагт хамааралтай зорилтуудыг хяналтад авч, хэрэгжилтийг хангах;</p> <p>2. Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Сайдын тушаал, Засгийн газрын хуралдаан, Ерөнхий сайд, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, ажлыг зохион байгуулж, биелэлт үр дүнг тайлagnaх, мэдээллээр хангах;</p> <p>3. Үндэсний болон дэд хөтөлбөрүүд, холбогдох бусад баримт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлт үр дүнг тайлagnaх.</p> <p>4. Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах, холбогдох дээд шатны байгууллагад тайлagnaх;</p>	<p>Бодлогын баримт бичгийг хэрэгжилт бүрэн хангагдсан байна.</p> <p>Бодлогын баримт бичгийг хэрэгжилт бүрэн хангагдсан байна.</p> <p>Бодлогын баримт бичгийг хэрэгжилт бүрэн хангагдсан байна.</p> <p>Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган суурь үзүүлэлт өссөн байна.</p>	X, Ш    Х, Ш    Г, Х, Ш



	1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, салбарын бодлого стратегийг боловсруулах;	Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичиг батлагдаж хэрэгжсэн байна.	Г, Х, Ш
2 дугаар зорилтын хүрээнд	2.Орон нутгаас батлан гаргасан бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах, тайлagna;	Хууль тогтоомжийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	Х, Ш
	3.Орон нутгийн төсвийн төлөвлөлтийг хөгжлийн бодлого стратегитай уялдуулан боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэх.	Хууль тогтоомжид нийцсэн төлөвлөлт хийгдэж холбогдох өвлийн төлөвлөлтийг хөгжлийн бодлого стратегитай уялдуулан боловсруулж холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлсэн байна.	Х, Ш
	1.Монгол улсын Засгийн газар болон Төрийн албаны зөвлөл, дээд шатны байгууллагаас сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах чиглэлээр батлан гаргасан тогтоол шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажиллах;	Батлагдсан дүрэм журам мөрдлөг болсон байна.	Х, Ш
3 дугаар зорилтын хүрээнд	2.Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг хоорондын ажлын уялдаа холбоог хангах ажлыг зохион байгуулах;	Ажлын уялдаа холбоо хангагдсан байна.	Х, Ш
	3.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумын төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, үр дүнд жил бүр хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөмж өгөх хяналт тавих.	Хяналт шинжилгээ хууль тогтоомжийн дагуу хийж, зөвлөмжээр хангасан байна.	Ш, Х
4 дүгээр зорилтын хүрээнд	Төрийн жинхэнэ албан тушаалтныг мэргэшүүлэх багц сургалт, албан тушаалын ажлын байран дахь сургалт, хөтөлбөрт хамруулах боломжийг бүрдүүлэх, байгууллагын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг гаргаж, хэрэгжүүлэх.	Хөтөлбөр хэрэгжиж албан хаагчдын чадавх дээшилсэн байна.	Х, Ш
	Төрийн жинхэнэ албан хаагчийн ерөнхий болон тусгай шалгалтыг зохион байгуулж явуулах, төрийн захирагааны болон үйлчилгээний албаны удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах.	Сул орон тоо хуулийн хүрээнд нөхөгдсөн байна.	Ш, Х



	Төрийн албан хаагчийн нөөц бүрдүүлэх, төрийн захиргааны албан хаагчид зэрэг, дэв олгох асуудлыг зохион байгуулах.	Хууль тогтоомжийн дагуу хийгдсэн байна.	Г, Ш, Х
	Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоог Засгийн газраас баталсан орон тооны дээд хязгаарт багтаан тогтоож, албан тушаалтныг ажилд томилох, сэлгэх, шилжүүлэх, ажлаас чөлөөлөх, шагнал, урамшил олгох, хариуцлага ногдуулах.	Холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн байна.	Г, Ш, Х
5 дугаар зорилтын хүрээнд	1. Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;	Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хангасан байна	Х, Ш
	2. Нутгийн захиргааны байгууллагаас үзүүлэх төрийн үйлчилгээний ил тод, наолттой бийдлийг холигийн үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх;	Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна.	Х, Ш
	3. Байгууллагын дэргэдэх ёс зүйн зөвлөлийг байгуулж, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ;	Төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчил гаралгүй байна.	Х, Ш
	4. Төрийн албаны стандартын хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулах, арга зүйн дэмжлэг үзүүлэх;	Стандартыг хэрэгжүүлэх талаар мэргэшлийн зөвлөгөөгөөр хангасан байна.	Х, Ш
	5. Аймгийн Засаг даргын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өдөр тутмын зөвлөгөө, мэдээллээр хангаж, мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх;	Мэргэшлийн удирдлагаар хангасан байна.	Г, Ш
	6. Аймгийн Засаг даргын Тамгын газрын өдөр тутмын ажлыг мэргэшлийн үндсэн дээр удирдан, зохион байгуулж, чиглүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих;	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гомдол гаралгүй байх.	Г, Ш
	7. Сумын Засаг даргын Тамгын газар, агентлагийн үйл ажиллагааг чиглүүлэн удирдах, арга зүйгээр хангах;	Мэргэшлийн удирдлагаар хангагдсан байна.	Г,Ш
	8. Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, байгууллагын болон бүтцийн нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангуулах ажлыг зохион байгуулах, ажлын үр дүнд үнэлгээ, дүгнэлт өгөх.	Төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна.	Г, Х, Ш



	9.Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, хяналт тавих, үр дүнг дээшлүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах;	Санхүүгийн зөрчилгүй ажилласан байна.	Г, Ш
	10.Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэмжээнд мөрдөх дүрэм, заавар, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж мөрдүүлэх, дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;	Дотоод үйл ажиллагааг зохицуулсан дүрэм журмыг баталж мөрдүүлсэн байна.	Г, Ш
	11.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлж ажлын гүйцэтгэл, үр дүнг Төсвийн ерөнхийлөн захирагчийн өмнө хариуцна.	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х, Ш

### III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй		
Мэргэжил	-эрх зүй /042/, -эдийн засаг /0311/, -бусад		
Мэргэшил	Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх		
Туршлага	Төрийн албанад 12-оос доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх		
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>- Үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх;</li> <li>- нэгжийн үйл ажиллагааг байгууллагын болон бусад нэгжийн үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах;</li> <li>- албан хаагчийн өөртөө итгэх итгэл, өөрчлөлтөд мэдрэмжтэй, уян хатан шинжийг дэмжих, тэдний санал, бодлыг нь сонсох, эргэх холбоотой байх, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;</li> <li>- шууд удирдуулах албан хаагчийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, зөрүүг арилгахад туслах, зөвлөх, чиглүүлэх, шаардлага тавих;</li> <li>- нэгжийн албан хаагчдад ажил үүргийг тэнцвэртэй, хуваарилах;</li> <li>- нэгжийн албан хаагчийн мэдлэг, ур чадвар, туршлага, авьяасыг бүрэн дайчлах;</li> <li>- нэгжийн үйл ажиллагааны эрсдэлийг илрүүлэх, шинжлэх, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулах, танилцуулах;</li> <li>- бусад</li> </ul>	
	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулж, харьцуулах, дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах</li> <li>- шийдвэрийн зерэг болон сөрөг үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх</li> </ul>	



		<ul style="list-style-type: none"> <li>- судалгааны арга зүй эзэмшсэн байх</li> <li>- бусад</li> </ul>
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>- хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах;</li> <li>- аливаа харилцааг зохицуулах арга замыг хууль тогтоомжид тусгуулах тусгах санал боловсруулах;</li> <li>- албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд аливаа асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх;</li> <li>- гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах;</li> <li>- тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний эерэг, серөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах;</li> <li>- бусад</li> </ul>
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> <li>- ёс зүйн хэм хэмжээг сахиж, хувийн зан төлөв, зарчимч, тууштай, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих, чиглүүлэх зэргээр үлгэрлэх;</li> <li>- нэгжийн үйл ажиллагаанд шинэлэг санаа, үйлчилгээг нэвтрүүлэх, уриалан чиглүүлэх албан хаагчдын шинэ санаачилга, бүтээлч үйл хандлагыг дэмжих;</li> <li>- хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд нэгжийн хамт олныг хошуучлах;</li> <li>- байгууллагын болон нэгжийн үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг нэгжийн хамт олонд тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх;</li> <li>- нэгжийн стратеги зорилтыг тодорхойлоходо хамт олны саналыг сонсох, тусгах, өөрчлөлтийг хийхдээ урьдчилан тооцоолж, манлайлан удирдах;</li> <li>- бусад</li> </ul>
	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах</li> <li>- компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах;</li> <li>- кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх</li> <li>- багаар ажиллах чадвартай байх;</li> </ul>

#### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Аймгийн Засаг дарга

<u>Албан тушаалд шууд харьялан</u> <u>удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект :</u>
Хэлтсийн дарга .....	- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
Ахлах мэргэжилтэн .....	- Төрийн албаны зөвлөл
Мэргэжилтэн .....	- Яам, тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, бусад аймгийн Засаг даргын Тамгын газар
Төрийн үйлчилгээний албан хаагч .....	- Аймгийн Иргэдийн Хурлын дарга, ажлын алба, хурлын тэргүүлэгч, - Аймгийн Засаг даргын орлогч



Нийт .....	- Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, түүний Тамгын газар - Иргэн, хуулийн этгээд, төсөл хөтөлбөрийн удирдлага
------------	---

#### V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
<u>Албан тушаал:</u> <b>ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА</b> ..... /...../ (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 20..... оны ..... дугаар сарын ..... -ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> <b>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ</b> <u>Шийдвэрийн огноо:</u> <b>22.05.11</b> <u>Дугаар:</u> <b>334</b>

#### VI. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН

Байгууллагын нэр:  
**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Шийдвэрийн огноо: .....

Дугаар: .....

(тамга/тэмдэг)

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА: ..... /...../

(Гарын үсэг)

(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

